



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/16

Хажуу шинэ ус

Хаврын морины уралдааныг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Эрүүгийн тухай хуулийн 16.10 дугаар зүйлийн 1 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 01 сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд , аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд сумын нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2.Хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдааны үед гарч болох болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийтэд таниулж ажиллахыг сумын Уяачдын холбооны нарийн бичгийн дарга (М.Ганбуд)-д даалгасугай.

3.Харьяалах нутаг дэвсгэртээ хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН